

**ШВЕЙЦАРЫН ХӨГЖЛИЙН АГЕНТЛАГИЙН БУЦАЛТГҮЙ ТУСЛАМЖААР
ХЭРЭГЖИЖ БУЙ “МОНГОЛ НОГОО” ТӨСЛИЙН 2016 ОНЫ ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**
(2016 оны жилийн эцсийн байдлаар)

2017 оны 03 дугаар сарын 30-ны өдөр

№	Хөтөлбөр/төслийн агуулга	Гүйцэтгэл			
1	“Монгол ногоо” хөтөлбөр-Төгсгөлийн үе шат Хэрэгжих хугацаа: 2016-2019 7F-09387.01.01 Гэрээ №81014302	Хөтөлбөрийн зорилго: Хүнсний ногооны салбарын тогтвортой хөгжлийг дэмжих, хүйсийн тэгш байдлыг хангах замаар ногоочдын, ялангуяа хөдөө, орон нутгийн жижиг тариаланчид, хот суурин газрын болон хот орчмын эмзэг бүлгийн өрхүүдийн амьжиргааг сайжруулахад дэмжлэг үзүүлэх юм.			
2	Санхүүжилтийн эх үүсвэр	Буцалтгүй тусламж			
3	Хэрэгжүүлэгч байгууллага/ хэрэгжих хугацаа	Монголын Хөдөөг Шинэчлэхийн Төлөө Фермерүүдийн Холбоо <i>Хамтран хэрэгжүүлэгч байгууллага:</i> Монголын фермер эмэгтэйчүүдийн холбоо ТББ НҮБ-ийн Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага <i>Үндэсний түнш байгууллагууд:</i> Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам Нийслэлийн засаг даргын тамгын газар, Нийслэлийн хүнс, хөдөө аж ахуйн газар, Сонгино-Хайрхан, Налайх, Хан-Уул дүүргийн хүнс хөдөө аж ахуйн хэлтэс Орон нутгийн засаг даргын тамгын газар Ургамал газар тариалангийн хүрээлэн Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэн Хандивлагч байгууллагууд/Олон Улсын ТББ-ууд Тогтвортой хөгжлийн боловсрол (ТХБ) төсөл, Сонгогдсон дүүргүүдийн гэр хорооллын цэцэрлэг, сургуулиуд (ШХА) ЕХ/ДХХААБ ажлын байрыг дэмжих төсөл			
4	Төсөл, хөтөлбөрийн зорилтууд	Үр нөлөө 1: Сайн чанарын үр, сорт, дэвшилтэт технологи, нөү-хауг үйлдвэрлэлд нэвтрүүлснээр хүнсний ногооны дотоодын үйлдвэрлэл нэмэгдсэн байна. Үр нөлөө 2: Хүнсний ногооны зах зээлийн таатай орчин бүрдэж, тогтворжсоноор ногоочдын буюу ялангуяа бага хэмжээний талбайтай ногоочид болон өрх толгойлсон эмэгтэйчүүдийн өрхийн орлого нэмэгдсэн байна. Үр нөлөө 3: Хотын болон хот орчмын эмзэг бүлгийн өрхийн хүнсний ногооны үйлдвэрлэл, хэрэглээг өрхийн хүнсний ногооны тариалалтаар нэмэгдүүлсэн байна. Үр нөлөө 4: Хүнсний ногооны салбарын бодлого/хууль эрх зүйн орчин сайжирсан байна.			
5	Зардал	Төсөв (нийт)	8.8 тэрбум төгрөг (5 сая швейцар франк) /Зорилт 1,2,3/		
		Үүнд :	Төсөв (2016 он)	Гүйцэтгэл	
		ШХА	2'400'000'000	1'718'295'273	Хувь 71%
		ХХААХҮЯ /шууд бус/	-	-	-
6	Хөтөлбөрийн зорилт :	Ажлуудын биелэлтийг доорх талбарт бичсэн.			

БҮРЭЛДЭХҮҮН ХЭСЭГ 1:
ХҮНСНИЙ НОГООНЫ
ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ
НЭМЭГДҮҮЛЭХ

1-р зорилтын хүрээнд :

Бүтээгдэхүүн 1.1-ийн үйл ажиллагаа:

Сайн чанарын үр, сорт, дэвшилтэт технологи, нөү-хауг үйлдвэрлэлд нэвтрүүлснээр хүнсний ногооны дотоодын үйлдвэрлэл нэмэгдсэн байна.

1. Хүнсний ногооны сорт сорилт

2016 онд Улсын сорт сорилтын зөвлөл (УССЗ) хуралдаж, хүлэмжийн өргөст хэмхийн Саладин F1, улаан лоолийн Толстой F1 эрлийз сортуудыг ирээдүйтэйгээр баталлаа.



Зураг 1: Өргөст хэмхийн Саладин сорт

Ийнхүү голлох нэр төрлийн хүнсний ногооны хувьд 6 нутагшсан, 15 ирээдүйтэй сорт, 12 эрлийз ирээдүйтэй сорт шинээр батлагдаад байна. Ялангуяа, хүлэмжийн ногоо тариалагчдад албан ёсоор соригдож, батлагдсан нэг ч эрлийз сорт байхгүй байсан юм. Хэрэв том аж ахуйн нэгжүүд санхүүгийн эрсдэлээ даан өөрсдөө янз бүрийн эрлийз үр оруулж ирж тариалдаг бол жижиг өрхийн тариаланчид үрийн жижиглэн борлуулагчдаас гарал үүсэл тодорхойгүй үрийг өндөр үнээр худалдан авахад хүрч, санхүүгийн

эрсдэлд ордог. Хүлэмжийн 2 эрлийз сорт маань хүлэмжийн аж ахуй эрхлэгчдээс болон тариаланчдаас өндөр ургац, бүтээгдэхүүний чанар, нийлэг хальсан хүлэмжин дэх өдөр шөнийн дулааны өндөр хэлбэлзэлд тэсвэртэй зэрэг давуу чанараараа өндөр үнэлгээ аваад байна. Монгол төмс хөтөлбөрийн Төгсгөлийн үе шатны үйл ажиллагааны үргэлжлэл болон 5 дахь жилдээ хүнсний ногооны сорт сорилтын ажлыг зохион байгуулан явуулж байна. Энэ жил хүнсний ногооны 18 зүйлийн 71 гаруй сортын үрийг оруулж ирэн сорилтод оруулав. Хүлэмжийн аж ахуй эрхлэгчдийн холбооноос гаргасан хүсэлтийн дагуу хүлэмжийн эрлийз өргөст хэмх, улаан лоолийн сорт туршихад илүү анхаарал хандуулан ажиллаа.

Эдгээр сортуудыг Дарханы УГТХ, Дархан-Уул аймгийн Орхон суман дахь УГТХ-ийн хүнсний ногооны сорт сорилтын талбар, Улаанбаатар хот дахь ХААИС-ийн сургалт үйлдвэрлэлийн талбайд, Ховд аймгийн сорт сорилтын талбай болон зарим хувийн хэвшлийн аж ахуйн нэгж зэрэг агро-экологийн хувьд ялгаатай 5 газарт сорив.

ХШҮ- 100 %

2. Хүнсний ногооны үр үйлдвэрлэл.


2016 онд тариаланчдын гаргасан хүсэлтийн дагуу эрлийз сортуудын үр нийлүүлсэн. Тухайлбал, байцаа (28 га), ил талбайн бусад ногоо (6,1 га), хүлэмжийн өргөст хэмх (14'400 м²) болон хүлэмжийн улаан лооль (48'000 м²). Мөн сонгины үйлдвэрлэлийн түвшинг нэмэгдүүлэх зорилгоор 25 тн (50 га-ийн үр) дэлхийн хэмжээнд танигдсан 'Stuttgarter risen' сортын үрийг Голландаас импортоор оруулж ирэн, 16 аймгийн хүнсний ногоо үйлдвэрлэгчдэд нийлүүлсэн.

Эдгээр Герман, Голландаас импортоор оруулж ирсэн өндөр ургац бүхий эрлийз сортууд нь хэдийгээр үнэтэй боловч тариаланчдын хэрэгцээ, таашаалд ихэд нийцсэн. Тухайлбал, нэгж талбайгаас өгөх ургац өндөр, өнгө үзэмж сайтай,

борлуулалт сайн, тээвэрлэлт болон хадгалалт даах чадвар өндөр, үр ариутгасан байдаг тул өвчин, хортонд тэсвэртэй, эрлийз сортын бусад онцлог шинж чанарууд зэрэг давуу талуудыг онцолж байв.

Тариалангийн цаг агаарын хувьд хүнсний ногооны үр үйлдвэрлэхэд тааламжтай зарим бүс нутгуудад хүнсний ногооны үр үйлдвэрлэл эрхлэх нь сүүлийн жилүүдэд хувийн бизнес болсон (өмнө нь улсын аж ахуй тусгайлан үр үйлдвэрлэл эрхэлж байв). Үүний зэрэгцээ хүнсний ногооны үрийн түгээлтийн сүлжээ байхгүй учир алс хөдөө орон нутгийн тариаланчдад сайн чанарын, өндөр бүтээгдэхүүнт чадвар бүхий сортын үрийн олдоц муу байдаг. МХШТФХ нь бүх аймагт салбартай бөгөөд эдгээр салбарууд болон үрийн дэлгүүрүүдээрээ дамжуулан тариаланчдад үрийг бөөний үнээр түгээж байна.

Сүүлийн үед шинээр ирээдүйтэй сортоор батлагдсан сортын үрийг УГТХ-ийн үр үйлдвэрлэлийн талбар дээр үржүүлж байна. 11 зүйл хүнсний ногооны 14 сортын үр үржүүлэгдэж байна. МНТ-өөс үр үржүүлгийн ажлыг дэмжиж усалгааны системийг сайжруулахад дэмжлэг үзүүлэн ажиллаа.



Зураг 2: Улаан лоолийн
Голстой сорт

2015 оны хавар Увс аймгийн МХШТФХ-ны салбарын гишүүд хүнсний ногооны лицензитэй үр үржүүлэгчид шар лууван, хүрэн манжин болон шар манжингийн үрийн улсын хэрэгцээний 50-60 %-ийн үрийг нийлүүлж байсан бол 2016 оны хаврын үрийн хэрэгцээний 80 %-ийг хангаж чадсан юм.

2015 онд Монгол улсын газар тариалангийн голлох бүс нутгаар ган гачиг болсон. Энэ нь хүнсний ногооны үйлдвэрлэлд сөргөөр нөлөөлж, тэр дундаа хүнсний ногооны үрийг голлон үйлдвэрлэдэг Увс аймагт шар луувангийн ургацын алдагдал 60-

70 %-д хүрсэн. Иймд төслийн зүгээс шар луувангийн үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор УГТХ, аймгийн агрономч болон төслийн багийн бүрэлдэхүүнтэйгээр сонгон шалгаруулж, төвийн бүсээс 11,3 тн эх ургамал нийлүүлсэн. Хэрэв 1 кг эх ургамлаас 200 гр үр үйлдвэрлэнэ гэж үзвэл дээрх 11,3 тн эх ургамлаас 2'260 кг үр үйлдвэрлэсэн байна.

Сүүлийн үед шинээр ирээдүйтэй сортоор батлагдсан үндэс үртэн болон байцааны шинэ сортын үрийг Увс аймагт, тарвас, амтат гуа, улаан лоольны үр үржүүлэг Ховд, Дорноговь, Баянхонгор аймгуудад тус тус явагдаж байна. Дулаансаг таримлын 76,5 кг үр хүнсний ногооны нөөц санд төвлөрөөд байна.

ХШҮ- 90 %

3. Хүнсний ногооны үрийн нөөц сан

Хүнсний ногооны үрийн нөөц санд дараа жилийн тариалалтанд 6'964 кг үр нөөцлөгдөөд байна. Гэрээт үр үржүүлэгчдийн сантай байгуулсан үр үржүүлгийн гэрээний биелэлт 92.7 % болсон. Гэрээний биелэлт дутсан нь 8-р сард үр үржүүлгийн бүс нутагт мөндөр цохисонтой холбоотой юм.

МХШТФХ-ны дэргэдэх уг сан 2016 оны хаврын тариалалтанд

	<p>зориулж хүнсний ногооны 7 зүйл таримлын 4'500 кг үрийг 17 аймаг дахь салбар холбоо, 2 үрийн жижиглэн борлуулагчдаар дамжуулан түгээсэн. Аймгууд дахь салбар холбоод жижиг өрхийн тариаланч болон холбоодын гишүүдээ үр нийлүүлэгч, дистрибьюторын үүрэг гүйцэтгэн ажиллаж байна.</p> <p>Салбар холбоод, аж ахуйн нэгжээс нийт 53 үрийн захилга ирсэн бөгөөд нөөцөнд байсан үрээ жигд хуваарилсан. Үрийн нөөц сан нь хөдөө орон нутаг, алслагдсан бүсийн ногоочид, тариаланчдад үндсэн төрлийн хүнсний ногооны үрийг бөөний үнээр нийлүүлэхэд зорин ажиллаж байна. Ийнхүү хүнсний ногооны үрийн чанар болон гарал үүслийг улсын түвшинд хянах боломж бүрдэж байгаа юм.</p> <p>2016 онд 2 судалгаа, шинжилгээний ажил дэмжиж ажиллав.</p> <p><u>Монгол оронд тариалагдаж байгаа сармисны сортуудад вирусын халдварыг илрүүлэх, оношлох:</u> Сармисны голлох 3 вирусын ELISA оношлуурыг ХБНГУ-аас импортоор оруулж ирсэн. УГТХ-ийн Биотехнологийн лабораторт газар тариалангийн баруун, зүүн, төвийн бүсээс цуглуулсан дээжинд вирусын оношлогоо болон нематодын халдварыг тогтоов. 6 аймгийн 8 сумын 192 дээжинд хийсэн оношлогооны дүнгээр өвчний тархалтын хувь 0-40% буюу дунд зэргийн тархалттай байв. Дараагийн шатны ажил бол дотоодын сармисны үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхийн тулд эрүүл үрийн материал үржүүлэх ажил юм.</p> <p><u>Хүнсний ногооны талбайн хортонтой биологийн аргаар тэмцэх</u> – ХААИС-ийн Агро-экологийн сургуулийн судлаачидтай хамтарсан хүлэмж болон ил талбайн хортонтой ангууч шавьж ашиглаж тэмцэх судалгааны ажил эхлэн явагдаж байна. 2 зүйлийн ангууч хачгийг лабораторийн нөхцөлд үржүүлэн, үржүүлсэн ангууч хачгийг 2 толбот хачиг гарсан өргөст хэмхний хүлэмжинд тавьж туршив. Дээрх туршилтыг мөн био-пестицид болон механик аргуудтай харьцуулав. Хүлэмжинд тавьсан ангууч хачгууд идэвхитэй хооллож, цааш үржиж байсан байна. Ангууч шавьжийг ургамлын гаралтай инсектицид (Neem oil)-тэй хослуулсан хувилбарт ургацын нэмэгдэл илүү байсан (28,7%). Дараагийн жил ангууч шавьжийн масс үржүүлгийн арга болон хадгалалт, тээвэрлэлт, хүлэмжинд тавих технологийн судалгаанууд хийгдэх болно.</p> <p><u>Хүнсний ногооны үр үйлдвэрлэл ба маркетингийн судалгаа</u> (11-р сар)</p> <p>Энэхүү судалгааны ажлаар дараах сэдвүүдээр судалгаа явуулж, дүгнэлт гаргав.</p> <p>2012 онд хийгдсэн хүнсний ногооны үр үйлдвэрлэлийн хэмжээ, хэрэгцээ, импортын хэмжээг тогтоохоос гадна үр үржүүлэгчдийн чадамжийг үнэлэх, үр үйлдвэрлэлийн эдийн засгийн үр ашгийг таримал тус бүрээр гаргах, технологийг сайжруулах зөвлөмж боловсруулах “Хүнсний ногооны үр үйлдвэрлэл, зах зээлийн талаарх судалгаа”-ны ажлын тоон мэдээллийг шинэчлэх, сүүлийн 4 жилд гарсан өөрчлөлтөнд дүгнэлт өгөх ажлын хүрээнд дараах үр дүн гарсан:</p> <p>Манай улс сүүлийн 4 жилийн (2013-2016 он) дунджаар 92,680 т хүнсний ногоо үйлдвэрлэсэн нь 2008-2012 оныхоос 6.5%-иар илүү байгаа боловч нэг га-гийн ургац 117.8 ц болж, өмнөх жилүүдийн дунджаас 5.6%-иар буурчээ. Түүнчлэн сүүлийн хоёр жилд өмнөх 2 оныхоос тариалсан талбай 725.5 га-гаар багасаж, хураан авсан нийт ургац 18.7%-иар доошилсон байна. Өнгөрсөн оны VII, VIII сард төв, хангайн бүс нутгаар гантай байсан нь хүнсний ногооны ургацад мэдэгдэхүйц сөрөг нөлөө</p>
--	--

	<p>үзүүлсэн нь үнэн. Гэхдээ зах зээлийн эрэлт хэрэгцээний баримжаагүй үйлдвэрлэл, борлуулалт, нийлүүлэлтийн зохицуулалтгүй тогтолцоо нь ногоо үйлдвэрлэгчдийг аажмаар цөхрөөж, энэ салбарын цаашдын хөгжилд саад тотгор болох магадлалтай гэж үзнэ. Ийм нөхцөлд 2020 оны түвшинд хүнсний ногоо тариалах талбайг 2016 оныхоос 800 га-гаар ихэсгэж, хураан авах ургацыг 185,310 т-д хүргэж, 2013-2016 оныхоос 2 дахин нэмэгдүүлэх төсөөлөл ихээхэн ээдрээтэй харагдаж байна.</p> <p>ХХААХҮЯ-ны төсөөллөөр 2020 он гэхэд хүнсний ногооны тариалах талбайн 30-аас доошгүй хувийг байцаа эзлэхээр тооцож байгаагаас үзвэл үрийн хэрэгцээ эрс нэмэгдэхээр болж байна. Үүний дотор 6-7 сар хадгалж хэрэглэх дунд оройн байцаа (байцаа тарих талбайн 70%) зонхилж, жил бүр 555-756 кг үр шаардлагатай. Иймд УГТЭШХ энэ оноос байцааны үрийн улсын хэрэгцээг бие даан хангаж байсан туршлага, материаллаг бааздаа (усалгаатай талбай, эх ургамлын зоорь гм) түшиглэн байцааны үр үржүүлгийн ажлаа сэргээвэл зохино.</p> <p>Увс аймаг дахь УГТЭШХ-гийн эрдэм шинжилгээний салбар, гэрээт үр үржүүлэгчид шар луувангийн нутагшсан “Шантэне 2461”, хүрэн манжингийн нутагшсан “Бордо 237” сортын үрийг өнөөг хүртэл үржүүлж ирсэн. Ирээдүйтэй сортын ангилалд бүртгэлтэй байсан шар луувангийн “Шантэне роял”, хүрэн манжингийн “Одноростковая” сортууд нэгэнт нутагшсан сортоор батлагдаж, аж ахуй, биологийн үзүүлэлтүүдээр нутагшсан хяналтын сортоо давамгайлах болсон тул хуучин сортыг тэдгээрээр солих шаардлагатай. Гэхдээ шинээр нутагшсан сортуудын үрийг шаардагдах хэмжээнд үржүүлж хангах хүртэл “Шантэне 2461”, “Бордо 237” сортуудыг шинээр нутагшсан сортуудтай зэрэгцүүлэн үржүүлэх болно. Иймд Улаангом суманд байрлах Эрдэм шинжилгээний салбар болон гэрээт үр үржүүлэгчдийн одоогийн эзэмшил талбайгаас 2 км-ээс доошгүй алслагдсан, усалгаатай шинэ талбай эзэмшүүлэх арга хэмжээ авах шаардлагатай.</p> <p>2012 оноос хойш МТХ болон МНТ-ийн шугамаар оруулж ирэн, хөнгөлөлттэй үнээр борлуулагдаж байгаа гибрид үрний зах зээлийн өртөг зардлын тооцоог хийх, цаашид зах зээлийн горимд шилжин борлуулах эдийн засгийн үндэслэлийг тооцоо ажлын хүрээнд дараах үр дүн гарсан:</p> <p>Төв, Сэлэнгэ, Орхон аймгийн 7 суманд байцааны үрслэгийг зуны хүлэмжид бэлтгэж, талбайд тракторын үрслэг суулгагчаар суулган, ургамлын мөр хоорондох хөрсийг техникээр сийрүүлж, хөдөлмөр хөнгөвчлөх технологийг ХХААХҮЯ-наас МХШТФХ-той хамтран туршиж, фермерүүдэд зааж сургах, сурталчлах, эрт, дундын болцтой гибрид F1 хэд хэдэн сортын үрээр хангах арга хэмжээ авч хэрэгжүүлсэн нь бодит үр дүнгээ өглөө. Гэвч байцааны үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх талаар төрөөс хүлээж байсан төсөөлөлд хүрч чадсангүй.</p> <p>Гибрид F1 сортын шар лууванг ургуулахад түүний 1 кг ургацын өртөг ердийн сортынхоос нэлээд өндөр байгаа юм. Энэ нь гибрид сортын үр өндөр үнэтэй байгаатай холбоотой. Иймээс гибрид сорт хэрэглэх нь эдийн засгийн хувьд ашиггүй байх магадлалтай. Гэхдээ 1 кг ургацын өртөг өндөр байгаа нь ургац борлуулалтын өнөөгийн зах зээлийн ханш хэтэрхий доогуур (240 төгрөг/кг) байгаатай холбоотой. Харин байцаа, хүрэн манжин, хүлэмжийн хэмх, лоолийн ургац, борлуулалтын үнэ харьцангуй өндөр тул гибрид үрээр ургуулахад эдийн засгийн ашигтай байна.</p>
--	---

	<p>Хүнсний ногооны төрөлжсөн болон элдэв идэшт шавьж, хог ургамалтай тэмцэхэд сонгомол үйлчилгээтэй, байгаль, орчин, хүн амьтанд хор, үлдэцгүй пестицид сонгож хэрэглэхэд үр үржүүлэгчдэд дэмжлэг үзүүлэх хэрэгтэй. Ялангуяа төл сонгино томоохон талбайд ургуулахад сонгомол үйлчилгээтэй гербицидгүйгээр ургац авах тухай санахын ч хэрэггүй.</p> <p>Үр үржүүлэгч фермерүүд тухайн таримлын нэг сортоор дагнах нь сорт бохирдохоос сэргийлэх үндсэн арга мөн. Тэрээр нэгээс дээш сорт үржүүлэх хэрэгцээтэй бол хоорондоо хангалттай алслагдсан хэд хэдэн талбайг түүнд эзэмшүүлэх шаардлага тулгарна. Түүнчлэн нэг таримлын өөр өөр сорт үржүүлэгч фермерүүд хөрш зэргэлдээ талбай эзэмшихийг хориглоно.</p> <p>МХШТФХ-ны дэргэдэх Хүнсний ногооны үрийн нөөц сангийн үйл ажиллагаанд өртөг зардлын тооцоог хийх, цаашид эдийн засгийн хувьд тогтвортой ажиллах үндэслэл болон бизнес төлөвлөгөөг боловсруулах ажлын хүрээнд дараах үр дүн гарсан:</p> <p>Үрийг нь дотоодод үржүүлж буй зонхилох таримлын үрийн аюулгүйн зохих нөөц бүрдүүлж хадгалахад учирч байгаа санхүүжилтийн хүндрэлийг даван туулахад төрийн зүгээс тодорхой хэмжээний оролцоо шаардлагатай байна.</p> <p><u>Хүнсний ногооны үрийн дэлгүүр</u></p> <p>Энэ жилийн борлуулалтын мэдээгээр 9 аймгийн 12 суманд байгуулагдаад байгаа хүнсний ногооны үрийн дэлгүүрүүдээр дамжин нийт 2,213 кг буюу 53.2 сая.₮-ийн үнэ бүхий хүнсний ногооны үр борлуулагдсан байна.</p> <p>2016 онд орон нутгийн хэмжээнд голлон тариалдаг хүнсний ногооны үрийг бөөний үнээр нийлүүлэх зорилгоор 4 аймгийн 4 суманд хүнсний ногооны үр борлуулах цэгийг байгуулан ажиллаа. МНТ-ийн зүгээс хүнсний ногооны үр борлуулах цэгийг байгуулахад шаардлагатай дэлгүүрийн лангуу, тавиур, тавцан, жин, бусад шаардлагатай материалаар хангасан. Өмнө нь тариаланчид гарал үүсэл, чанар нь тодорхой бус ногооны үрийг өндөр үнээр хүнсний ногооны үр борлуулагчдаас худалдан авдаг байсан. Дээр нь эдгээр дэлгүүрүүд нь бүгд Улаанбаатар хотод байрладаг бөгөөд гол төлөв бага хэмжээгээр савласан, үнэтэй үр зардаг бол тариаланчид кг-ын үр худалдан авах сонирхолтой байдаг.</p> <p>ХШҮ- 90 %</p> <p>Бүтээгдэхүүн 1.2-ийн үйл ажиллагаа: Хүнсний ногооны үйлдвэрлэл нэмэгдсэн байна.</p> <p>Үндэсний статистикийн газраас мэдээлснээр 2016 онд өмнөх онтой харьцуулахад БНХАУ-аас импортлох байцааны хэмжээ 972.2т-оор буурсан боловч импортын зардал 126.5 мян.ам доллараар нэмэгдсэн байна. Энэ нь өнөө жил импортын байцаа дотоодын үйлдвэрлэлийн байцаанаас үнэтэй байсныг илтгэж байгаа юм.</p> <p>Байцааны үрслэг бойжуулах төв байгуулагдаж, байцааны шинэ эрлийз сорт нэвтрүүлж болон Улаанбаатар хотод байцааны төрөлжсөн 1'000 т-ны багтаамжтай зоориуд байгуулагдаж байгаа нь ойрын ирээдүйд дотоодын байцааны үйлдвэрлэл нэмэгдэх үндэс суурь болно гэж үзэж байна.</p> <p>Эрлийз байцааны тариалалт үрийн захиалгын хэмжээнээс тооцож үзэхэд 2017 оны хаврын тариалалтад 155.8 га-д хүрэх тооцоо байна.</p> <p>2014 оноос газар тариалангийн төвийн бүсийн 4 аймгийн 7 суманд байгуулагдаад байсан “Байцааны үрслэг бойжуулах төв” дээр нэмж 2016 онд Хэнтий аймгийн Мөрөн сум, Ховд</p>
--	--

	<p>аймгийн Буянт суманд 2 төв байгуулагдсан.</p> <p>Байцаа тариалдаг уламжлалт бүс нутагт давхар нийлэг хальсан бүхээгэн доор байцааны үрслэг бойжуулах технологийг нэвтрүүлээ. Дээрхи байцааны үрслэг бойжуулах шинэ технологийн зэрэгцээ Голландын Вежо үрийн компанийн байцааны шинэ гибридүүд, шинэ пестицид болон 2 мөрний байцааны үрслэг суулгагчийг туршив.</p> <p>2016 онд МНТ, МХШТФХ-ны Мандал суман дахь салбар болон сумын ЗДТГ шинээр баригдсан зоорины 300 тн-ны багтаамжтай байцааны зоорийг урт хугацааны түрээсийн байдлаар ашиглах талаар хамтран ажиллаа. Сумын ЗДТГ болон МНТ-ийн зүгээс зоорийг ашиглахад шаардлагатай тоног төхөөрөмж болох сэрээт өргөгч болон 500 кг-ын багтаамж бүхий сараалжин контейнерүүд нийлүүлээд байна.</p> <p>Байцааны зах зээл, борлуулалтын асуудал анхаарал татсан хэвээр байна. Байцааны үрслэг ургуулах ажил 3-р сарын дундаас эхэлдэг ба үрслэг ургуулах, ил талбайд шилжүүлэх суулгах, усалгаа болон байцааны албан ёсны бүртгэлтэй гербицид байхгүй байгаа тул хог ургамлыг нь гараар устгах зэрэг маш их хэмжээний гар ажиллагаа шаардсан таримал хэдий ч ургац хураалтын үед бөөний үнэ нь 100₮ хүртэл унах эрсдэл тохиолддог. Энэ үед хураалт, тээвэрлэлт зэрэг нэмэлт зардал гаргаж, 1кг-ыг нь 100₮ борлуулахад өөрийнхөө өртгийг ч нөхөхгүй тул зарим тариаланчид илүү зардал гаргаж эрсдэл хүлээхээс сэргийлж, ургуулсан байцаагаа хураалгүй талбайд нь хаяхад хүрдэг.</p> <p>120 м²-ийн хүлэмж 12 ширхэг, 32м²-ийн хүлэмж 52 ширхэг (нийт 3'824м²) 16 аймгийн 25 сумдын ногоочдын бүлгийн дундын хэрэгцээнд буцалтгүй тусламж хэлбэрээр олгосон. Энэ нь зорилтот бүс нутгийн хамгаалагдсан хөрсний талбайг 5%-иар нэмэгдүүлсэн байна. Унгар Улсаас импортоор түрдэг болон гар багажны иж бүрдэлийг, мөн эрдэс, органик бордоо, сайн чанарын ургамал хамгааллын бодисыг хуваарилан олгосон.</p> <p>Хүнсний ногооны үйлдвэрлэл үр тариа болон төмсний үйлдвэрлэлтэй харьцуулахад хамгийн бага механикжуулалтын хувьтай (40%). Хүнсний ногооны үйлдвэрлэлд дунд юмуу том оврын техникээс илүү бага оврын юмуу гар ажиллагаатай техник илүү тохиромжтой байдаг нь ихэнх хүнсний ногоо тариалдаг талбай бага хэмжээтэй, голын хөндийг дагуу байрласан байдагтай холбоотой.</p> <p>25 морины хүчин чадалтай бага оврын тракторт холбож ажилладаг 10 ширхэг эрдэс бордоо цацагч, 12 ургамал хамгааллын бодис шүршигчийг Польшоос импортоор оруулж ирэв. Эдгээр техник, тоног төхөөрөмжийг Төв, Сэлэнгэ болон аймгийн хэмжээнд газар тариалангийн тоног төхөөрөмж хүрэлцээгүй Баян-Өлгий, Ховд, Увс зэрэг аймгийн хүнсний ногоо тариаланчдад нийлүүлээ.</p> <p>Өрхийн болон жижиг хэмжээний хүнсний ногоо үйлдвэрлэгчдэд эрдэс бордоо цацах тоног төхөөрөмж байхгүй</p>
--	---



Зураг 3: Байцаа хадгалах зориулалтын хайрцаг, Сэлэнгэ аймгийн Мандал сум

	<p>тул гараар цацдаг мөн үүргэвчин хор шүршигч хэрэглэдэг. Дээрх 25 морины хүчин чадалтай тракторт холбож ажилладаг бага оврын тоног төхөөрөмжийг нэвтрүүлснээр эрдэс бордоо болон ургамал хамгааллын бодистой шууд харьцахгүй болно гэсэн үг юм. Тоног төхөөрөмжүүдийг сумын бүх тариаланчид түрээслэн ашиглах болно. Жишээлбэл, Төв аймгийн Жаргалант сум бага оврын ургамал хамгааллын бодис шүршигчээ энэ зун 200 га талбайд ашигласан байна.</p> <p>25 морины хүчин чадалтай бага оврын тракторт зориулсан 4 мөрийн цагийн 700 м²-ийн бүтээмжтэй сонгины үрлэгчийг Сэлэнгэ аймгийн Мандал сумын тариаланч Ц.Цогтбаатар угсарч бүтээв. Өөрийнхөө сонгины талбайд амжилттай туршсаныг төслийн баг ургалтын хугацаанд хэд хэдэн удаа газар дээр нь очиж танилцсаны дүнд сумын загвар экстейншин төвүүддээ зориулан 3 ширхэгийг захиалж хийлгүүлсэн. Эдгээр тоног төхөөрөмж нь мөн тариаланчдад түрээсийн журмаар үйлчлэх юм.</p> <p>МНТ хэрэгжсэнээр орон нутгаас ирүүлсэн статистикийн мэдээгээр, зорилтот 12 сумын хүнсний ногооны тариалсан талбайн хэмжээ 2015 онтой харьцуулахад 31%-иар (2,708га-аас 3,929га), хүнсний ногооны үйлдвэрлэл 2015 онтой харьцуулахад 36%-иар (25,591 тонноос 40,009 тонн) тус тус нэмэгджээ.</p> <p>ХШҮ-90%</p> <p>Бүтээгдэхүүн 1.3-ийн үйл ажиллагаа: Ногоочдын мэдлэг, мэдээлэл нэмэгдсэн байна. <u>Анхны сумын загвар экстейншин төвийг</u> Дархан-Уул аймгийн Орхон суманд байгуулаад байна. Уг төв нь туршилтын 500м² талбай бүхий, сургалт, оффисын, өрөө, үрийн дэлгүүрийн барилгатай.</p> <p>Загвар экстейншин төвийн зорилго:</p> <ol style="list-style-type: none"> 1. Танхимын болон талбайн хүнсний ногооны шинэ технологи, сорт, ургамал хамгааллын чиглэлийн цуврал сургалтууд сумын нийт ногоочдод зориулан явуулах; 2. Хүнсний ногооны шинэ технологи, сорт, ургамал хамгааллын чиглэлээр мэргэжлийн зөвлөх ирж, сумын ногоочдын талбайгаар явж зөвлөгөө өгөх; 3. Хүнсний ногооны нутагшсан болон шинэ ирээдүйтэй сортуудыг танилцуулах;
--	--



Зураг 4: Мандал сумын тариаланч залуу 4 мөрийн сонгины үрлэгчийг зохион



Зураг 5: Дархан-Уул аймгийн Орхон суманд экстейншин төв нээгдлээ

		<p>4. Хүнсний ногооны нутагшсан болон шинэ ирээдүйтэй сортуудын үр, бордоо, ургамал хамгааллын бодис нийлүүлэх;</p> <p>5. Бага оврын техник, тоног төхөөрөмжийн түрээсийн үйлчилгээ явуулах.</p> <p>Сэлэнгэ аймгийн Мандал сум, Төв аймгийн Борнуур суманд байгуулагдах загвар экстейншин төвийн газрын асуудал шийдэгдэх шатанд явж байгаа. Тухайлбал, сумын ЗДТГ-аас экстейншин төвд зориулан газрыг үнэгүй олгохоор тохироод байна.</p> <p>Хүснэгт 1: Сургалт, туршлага судлах аялал:</p>		
№	Сургалтын нэр	Хугацаа, байршил	Оролцогсод (% эмэгтэй)	Сургалтын үр дүн
1	Хүлэмжийн сургалт Төвийн бүс	5-р сарын 2-4 Сэлэнгэ, Төв, Дархан-Уул аймгийн 11 сумын тариаланч	166 (52.4% эм)	Ногоочид хүлэмжинд өргөст хэмх, улаан лооль, цэс, амтат чинжүү болон бусад ногоог ургуулах онол, практикийн мэдлэг олж авсан.
2	Хүлэмжийн сургалт Зүүн бүс	8-р сарын 1-4 Хэнтий, Сүхбаатар, Дорнод аймгийн 11 сумын тариаланч	104 (58.7% эм)	Хүлэмжийн нөхцөлд ашиглаж болох ургамал хамгааллын голцуу биологийн тэмцэх аргуудыг мөн танилцуулсан. Уг сургалтанд сургагч багшаар Хүлэмжийн аж ахуй эрхлэгчдийн холбооны зөвлөхүүд ажилласан. Тариаланчид зөвлөхүүдийн зүгээс өгсөн практик зөвлөмжүүдийг ихэд таашаан хүлээж авч байв.
3	Хүлэмжийн сургалт ХААИС	6-р сарын 9-10 УБ, Сэлэнгэ, Төв, Дархан-Уул аймгийн 5 сумын тариаланч	11 (63.6% эм)	Ногоочид хүлэмжинд хүнсний ногоог ургуулах онол, практикийн мэдлэг олж авсан. Уг сургалтыг БНСУ-ын КОЙКА төслөөс хамтран зохион байгуулсан юм.
4	Сонгино, сармис ургуулах	8-р сарын 22-24 Увс, Ховд, Завхан аймгууд	59 (32.2% эм)	Ногоочид сонгино, сармис ургуулах талаар дэвшилтэт технологийн онол, практикийн мэдлэг олж авсан. Мөн зарим ургамал хамгааллын зөвлөгөөг өгөв.
5	“Хүнсний ногооны шинэ сорт болон технологи” Олон улсын сургалт	6-р сарын 5-25 БНХАУ, Хефэй БНХАУ-ын ЗГ-аас “Хөгжиж буй орнуудад үзүүлэх дэмжлэг” хөтөлбөрийн хүрээнд санхүүжүүлсэн	3 ЭША УГТХ Х/н-ны сектор (100% эм)	Судлаачид олон улсын эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагуудын гаргасан газар тариалангийн үйлдвэрлэлд нэвтрүүлсэн шинэ дэвшилтэт техник, технологи, шинэ бүтээгдэхүүн болон сорт сорилт, селекци, сортын зохиогчийн

				эрх хамгаалах, газар тариалангийн зохистой менежмент зэрэг хөдөө аж ахуйн шинжлэх ухаан, технологийн салбарт гарсан дэвшлийн талаар мэдээлэл олж авах, танилцах боломж бүрдсэн юм.
6	Туршлага судлах аялал БНСУ	11-р сарын 1-6 - КИEMSTA 2016 (БНСУ-ын ХАА-н техник, тоног төхөөрөмж, шинжлэх ухаан технологийн олон улсын үзэсгэлэн) - Garak зах, ХАА-н олон нийтийн зах, - Hongik Bio ХХК, (төмс, хүнсний ногоо).	14 (53.9% эм)	Хүлэмжийн аж ахуй, газар тариалангийн сүүлийн үеийн шинэ техник, тоног төхөөрөмж, багаж, хэрэгсэлтэй танилцаж, Монголд нэвтрүүлэх, таниулах боломжийг судлах, Солонгосын шаардлагатай компаниудтай холбоо тогтоов.
	НИЙТ	24 өдөр	357 (51% эм)	

МНТ-ийн эхний “Нийлэг хальсан хүлэмжинд хүнсний ногоо ургуулах” гарын авлагыг бэлтгэн гаргав. Хүлэмжийн үндсэн 5 таримал болон зарим навчит ногоо ургуулах технологи, ургамал хамгааллын сэдвүүдийг хамарсан.



Зураг 6: Хүлэмжийн сургалт, Дорнод аймаг



Зураг 7: Хүлэмжийн ногооны гарын авлага

Хүснэгт 2: Шууд ба шууд бус үр шим хүртэгчид, хүнсний ногоо тариалсан талбай, ургацын хэмжээг 2015, 2016 онтой харьцуулав.

Аймаг/сум	Үр шим хүртэгчид		Хүнсний ногоо тариалсан талбай (га)		Нийт хураан авсан ургац (тонн)	
	Шууд	Шууд бус	2015	2016	2015	2016
Төв аймаг						
Борнуур	51 (51% эм)	629	206	212	2,080	2,250
Жаргалант	89 (22% эм)	954	19	123	3	1,285
Батсүмбэр	21 (52% эм)	126	52	72	107	435
Баянчандмань	32 (28% эм)	317	88	139	483	511
Бүгд	193 (34% эм)	2'026	365	546	2'673	4'481
Сэлэнгэ аймаг						
Мандал	17 (24% эм)	1'710	456	430	7,885	6,625
Шаамар	33 (48% эм)	183	187	248	2,539	3,685

	Хушаат	62 (55% эм)	110	117	161	1,169	1,862
	Зүүнбүрэн	23 (57% эм)	220	173	298	1,627	2,641
	Сант	31 (26% эм)	314	171	259	2,297	2,474
	Баянгол	43 (60% эм)	189	117	87	1,390	832
	Бүгд	209 (48% эм)	1'016	1'221	1'483	16'907	18'119
	Бусад аймаг						
	Улаангол, Увс	35 (14% эм)					
	Орхон, Дархан	18 (61% эм)	531	942	1,664	3,801	14,294
	Жаргалант, Орхон	55 (45% эм)	342	181	235	2,210	3,115
	Бүгд	108 (38% эм)	873	1'123	1'899	6'011	17'409
	НИЙТ	510 (41% эм)	3'915	2'708	3'929	25'591	40'009
	<i>Эр сурвалж: төслийн тоон мэдээлэл болон сумдын мал эмнэлэг үржлийн тасгаас авсан мэдээ</i>						
	Нийт 8 (үүнээс 2 эр) зөвлөх, судлаач богино хугацааны гэрээтэйгээр ажиллалаа.						
	ХШҮ-50 %						
	БҮРЭЛДЭХҮҮН ХЭСЭГ 1 -ИЙН ҮР ДҮНГ ИЛТГЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН ГҮЙЦЭТГЭЛ						
	Үр дүнгийн үзүүлэлтүүд		2017 оны байдлаар				
			Төлөвлөсөн	Гүйцэтгэл	Хувь		
	Шинээр батлагдсан сортын тоо		2	2	100%		
	Зорилтот бүсийн хүнсний ногоо тариалах талбайн хэмжээ (га)		(>20%) 2.708	(30%) 3,929	100%		
	Зорилтот бүсийн хүнсний ногооны үйлдвэрлэл (тн)		(>20%) 25.591	(36%) 40,009	100%		
	Дундаж				100%		
БҮРЭЛДЭХҮҮН ХЭСЭГ 2: ХҮНСНИЙ НОГООНЫ МАРКЕТИНГ	Бүтээгдэхүүн 2.1-ийн үйл ажиллагаа:						
	Маркетингийн (тариаланчдын бүлэг/хоршооллууд) хамтарсан үйл ажиллагааны суурь тавигдана.						
	“Төсөл нь бага талбайтай ногоочдыг дэмжсэнээр тариаланчдад тулгамддаг маркетингийн асуудлыг шийднэ. Нэгдсэн маркетинг нь ханган нийлүүлэгчдийн наймаалцах эрхийг сайжруулж, ногоочдоос гар дээр өгөх үнийг өсгөж, хүнсний ногоо тарихад олох ашгийг нэмэгдүүлнэ.”						
	ҮЗЭСГЭЛЭН ХУДАЛДАА – 4 үзэсгэлэн худалдаанд 7 аймгийн 80 ногоочин/хоршоо хамрагдаж 335.5 сая төгрөгийн борлуулалт хийв.						
	“Хүлэмжийн ногооны үзэсгэлэн худалдааг” 2016 оны 6-р сарын						
2-р зорилтын хүрээнд :							
	Зураг 8: Намрын ногоон өдрүүд						
	24-26-ны хооронд Хүлэмжийн аж ахуйн эрхлэгчдийн холбоо, НҮБ, Глобал Коммюнитиз, ХХААХҮЯам, Чингэлтэй дүүрэг болон Монгол Ногоо төсөл хамтран Улаанбаатар хотод зохион байгуулсан. Энэхүү үзэсгэлэн худалдааны зорилго нь хүлэмжийн аж ахуй эрхлэгчдийг олон нийтэд таниулах, борлуулалт хийх, хэрэглэгчдийн тоог нэмэгдүүлэх явдал байв.						

16 байгууллага оролцож, 5'000 хүн зочилж, нийт 100 сая төгрөгний борлуулалт хийгдсэн.

“Намрын ногоон өдрүүд” үзэсгэлэн худалдааг 2016 оны 9-р сарын 14-20-ны хооронд ХХААХҮЯам болон бусад байгууллагууд хамтран зохион байгуулав. Төсөл уг арга хэмжээнд хүнсний ногооны шинэ сортууд болон хоршооны бүтээгдэхүүнийг сурталчилж, хүнсний ногооны хэрэглээний боловсролыг дэмжих үйл ажиллагаа явууллаа. Нийт 7 аймгийн 40 ногоочид (22 эмэгтэй, 18 эрэгтэй) хамрагдан 165 сая төгрөгний борлуулалт хийсэн. Төсөл Глобал Коммюнитиз олон улсын байгууллагатай хамтран “Ногоон хүнс – эрүүл амьдрал” өдөрлөг зохион байгуулж, хүнсний ногооны хэрэглээ, эрүүл хооллолтыг дэмжих арга хэмжээ явуулсан. Төсөл үзэсгэлэн худалдаанд оролцсон шилдэг байгууллагаар тодорч, төслийн үр шим хүртэгч 5 ногоочин тодорхой шагнал хүртлээ.

“Ногоочдын нээлттэй өдөрлөгийг” МХШТФХолбооны зүгээс Сонгинохайрхан дүүрэгт 2016 оны 9-11-р сард зохион байгуулсан. 6 сумын 24 ногоочин хамрагдаж 70.5 сая төгрөгний борлуулалт хийсэн.

“Солонгос – Монголын хамтарсан газар тариалан, эрчим хүчний үзэсгэлэн худалдаа & K-Food 2016” 10-р сарын 26-28-ны хооронд зохион байгуулагдсан. ХХААХҮЯ, ХААИС, Солонгос Монголын Бизнес Төв хамтран ХААИС дээр зохион байгуулав. Төслийн зүгээс мэдээлэл түгээж, Орхон, Шаамар сумын ногоочид арга хэмжээнд оролцож бүтээгдэхүүнээ сурталчиллаа.

“Борнуур сумын 150-200т-ын багтаамжтай сонгины зоорийг өргөтгөн засварлаж, тоног төхөөрөмж суурилуулав”. Үүний



Зураг 9: Борнуур сумын 150-200т-ын багтаамжтай сонгины

дүнд “Борнуур ургац” хоршоо өвлийн туршид сонгино хадгалж, нийлүүлэлт багатай үед өндөр үнээр борлуулж, барагцаагаар 200 сая төгрөгний нэмэлт орлого олох боломжтой болсон.

“Ховдын тарвас, Өмнөговийн Булганы улаан лоолийг Улаанбаатар луу тээвэрлэхэд дэмжлэг үзүүлэв.” Төслийн зүгээс 2016 оны 9-р сард 15 т тарвас, амтат гуаг Ховд аймгаас Улаанбаатар хот руу 1'580 км зайд тээвэрлэх, Өмнөговь аймгаас 1200 кг улаан лоолийг Улаанбаатар хүртэл 553 км зайд тээвэрлэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлэв. Үүний дүнд “Намрын ногоон өдрүүд” үзэсгэлэн худалдааны үеэр Ховдын ногоочид бүтээгдэхүүнээ 2 дахин өндөр үнээр борлуулсан болон Өмнөговийн ногоочид улаан лоолио богино хугацаанд зарж борлуулж дууссан. Ховд аймгийн ногоочид 15 сая орчим төгрөгийн нэмэлт орлого оллоо.

ХШҮ- 70 %

Бүтээгдэхүүн 2.2-ийн үйл ажиллагаа: Маркетингийн сувгууд нэгдсэн удирдлага, зохион байгуулалтанд орно.

	<p>“Зах зээлийн ил тод байдал, ханган нийлүүлэгч, худалдан авагчдын өрсөлдөөн нь ажиллагаа сайтай өртгийн сүлжээ, шударга зах зээлийн нөхцөл үүсэхэд дөхөм болно. Ажиллагаа сайтай өртгийн сүлжээ нь орлогын ашгийг сүлжээний талууд (хүнсний ногоо үйлдвэрлэгч орно) шударга хуваарилахад үүснэ.”</p> <p><u>“Хүнсний ногооны бөөний зах”</u>, 4 хүнсний бөөний худалдааны төвийн удирдлагатай уулзсаны дараа Улаанбаатар хотын баруун хэсэгт байрлах “Тэнгэр” болон зүүн талын “Сэлэнгэ” захтай хамтран ажиллахаар тохиролцсон.</p> <p><u>“Өмнөд Солонгосын GARAK хөдөө аж ахуйн захаас туршлага судлав.”</u> Төслийн багийн гишүүд, төсөлд хамрагдагч ногоочид болон ХХААХҮЯамны мэргэжилтнүүд 2016 оны 11-р сарын 1-6-ны хооронд Өмнөд Солонгост зочилж, тус орны хамгийн том хөдөө аж ахуй, далан бүтээгдэхүүний GARAK захад зочлон үйл ажиллагаа, борлуулалтын арга барил, дуудлага худалдаа зэрэгт суралцлаа. Үүний дүнд төсөл болон ХХААХҮЯамны мэргэжилтнүүд хамтран олон нийтийн эзэмшлийн хүнс, хөдөө аж ахуйн зах байгуулах төсөл бичиж, Хөгжлийн Банкинд зээл авах хүсэлт явуулсан байна.</p> <p><u>“Хүнсний ногооны маркетингийн форумыг”</u> зах зээлд оролцогч талуудын ойлголцол, хамтын ажиллагааг нэмэгдүүлэх зорилгоор зохион байгуулсан. Форумын хүрээнд зах зээлд тулгамдсан асуудлыг тодорхойлох хэлэлцүүлэг, сургалт, хотын аялал зохион байгуулав. Форумд ХХААХҮЯам, Нийслэлийн ХХААГазар, НҮБ-н ХХААБ, Швейцарийн Хөгжлийн Агентлаг, Монголын хүнс, хөдөө аж ахуйн үндэсний ассоциаци, Хүлэмжийн аж ахуй эрхлэгчдийн холбоо, Глобал Коммюнитиз, Монголын Фермер Эмэгтэйчүүдийн Холбоо, Хөдөө аж ахуйн бирж, Органик Монгол хөдөлгөөн, ММСГ ХХК, ХААИС, Ургамал Газар Тариалангийн Хүрээлэн, Модерн номадс, хүнсний ногооны бөөний болон жижиглэнгийн худалдаа эрхлэгчид, Миш Маш ХХК, Номин, Макс, Делта Фүүдс, МТС Агро, Хил Хамгаалах ерөнхий газар, IFAD, Дэлхийн Банк, MOGFA, VEG, МУШУТИС, GERES, Хүнсний ногоочдын холбоо, МХШТФХ, ХХОД ТББ зэрэг 30 байгууллагын 161 төлөөлөгч оролцов. Уг арга хэмжээний талаарх мэдээлэл 248’313 хүнд хүрсэн байна.</p> <p><u>“Хүнсний ногооны зах зээлийн судалгааг”</u> 2016 оны 10-12-р сарын хооронд ММСГ ХХК хийж гүйцэтгэлээ. Энэхүү судалгаа нь хүнсний ногооны зах зээлийн хэмжээ, эрэлт, нийлүүлэлт, оролцогч талууд болон өртгийн сүлжээний шинжилгээ, борлуулалт, түгээлтийн суваг, үнэ бүрдэлтийг судаллаа. Уг цогц судалгааны дүнд төслийн баг хүнсний ногооны зах зээлийн өнөөгийн нөхцөл байдлын талаар цогц ойлголттой болж, маркетингийн стратеги, төлөвлөлт гаргах суурь бүрдэв.</p> <p>Онцлох үр дүнгүүд:</p> <ul style="list-style-type: none"> • 2016 онд 56’949 тн хүнсний ногоо импортлсон.
--	---



Зураг 10: Хүнсний ногооны маркетингийн форум


		<p>Үүний 74% нь Хятадаас орж ирж байна. Нийт импортын ногооны 56% гаруйг бөөрөнхий байцаа, лууван, сонгино эзэлжээ.</p> <ul style="list-style-type: none"> • Ногоочдын 47 % нь ногоо тариалалт, борлуулалтын хоршоо байгуулахыг дэмжсэн. • Нийтийн хоол үйлдвэрлэлийн салбар сард дунджаар 157'743 тн хүнсний ногоо хэрэглэж байна. • Өрхийн сарын дундаж хүнсний ногооны хэрэглээ 31 кг байна. Монгол хүн өдөрт дунджаар 260 г хүнсний ногоо хэрэглэж байгаа нь зохих ёсны түвшнээс 60 г-аар бага байна. <p><u>“Гадаад, дотоодын оюутны судалгааны ажлыг дэмжих”</u>. Төслийн зүгээс Швейцарийн НАFL их сургуулийн оюутан Lisa Erags болон СЭЗДС-ийн оюутан Г.Хашгэрэл нарыг дэмжиж ажиллав. Лизагийн судалгааны зорилго нь бага талбайд ногоо тариалагчдын үйлдвэрлэл, маркетингийг судлах явдал байсан. Судалгааны үр дүн тэр дундаа өртгийн сүлжээний шинжилгээ төсөлд чухал ач холбогдолтой байлаа.</p> <p>ХШҮ- 30 %</p> <p>Бүтээгдэхүүн 2.3-ийн үйл ажиллагаа: Зах зээлийн оролцогч талууд зах зээлийн мэдээллийг авах боломжтой болсон байна.</p> <p>Вэбсайт, социал медиа</p> <p><u>“Монгол ногоо төслийн вэбсайт”</u>. Ногооны үнийн мэдээлэл ил тод бус байдаг. Мөн тариалалт, боловсруулалт, маркетинг, борлуулалтын мэдээлэл дутмаг. Иймээс төслийн зүгээс холбогдох бүх мэдээллийг нэг дор оруулсан www.mfard.mn вэбсайт хийж байна. Үүний тусламжтайгаар борлуулагч, худалдан авагчид хоорондоо хялбархан холбогдох боломжтой болно. Вэбэд худалдаалагч, нийлүүлэгчийн цогц мэдээлэл, хүнсний ногооны төрөл, сорт, хэрэглэх болон тариалах аргачлалын мэдээлэл агуулагдаж байна.</p> <p><u>“Социал медиа сувгууд”</u>. Төсөл хэрэглэгчийн боловсролыг дээшлүүлэх бүхий л контентыг Facebook (MonVEGI) болон Youtube дээр байршуулж байна. 2017 оны 1-р сарын 7-ны байдлаар фэйсбүүк хуудас 15.300 дагалдагчидтай болов.</p> <p>ХШҮ- 70 %</p> <p>Бүтээгдэхүүн 2.4-ийн үйл ажиллагаа: Хүнсний ногоо боловсруулах санаачлагуудыг дэмжсэн байна.</p> <p>“Одоогоор хүнсний ногоо боловсруулалтын цөөн аргыг хэрэглэж байгаагийн дийлэнх нь даршлах арга. Илүү олон технологийг ашиглаж болох ба үүнд хатаах, гүн хөлдөөх гэх мэт орно. Цаашид боловсруулалтыг өрхөөс аж үйлдвэрийн гэсэн өөр өөр түвшинд хийж болно.”</p> <p><u>“Дорнод аймаг дахь хүнсний ногоо боловсруулах цехийг дэмжив”</u>. Дорнод аймгийн ногоочдын бүлэг “Хатан Шоргоолж” цех төслийн дэмжлэгтэйгээр байгуулагдан, 2016 оны 12-р сард нээлтээ хийж, ногооны салат, жүүс, кимчи, жимсний салат хийж байна. Төслийн зүгээс мэргэжилтэн илгээж газар дээр нь цогц сургалт, зөвөлгөө олгосон. Уг үйл ажиллагааны үр дүнд 1.5 сарын дотор 1'734'000 төгрөгийн үнэ бүхий 3'200 ширхэг бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн байна.</p> <p>ХШҮ-30%</p> <p><u>“Veggie Cook Show кампанит ажлыг”</u> МОНХХ /Монголын Органик Ногоон Хүнсний Холбоо ТББ/-тай хамтран хийв. Энэхүү кампанит ажлын зорилго нь хүнсний ногооны хэрэглээг</p>
--	--	---

		<p>нэмэгдүүлж, ач холбогдлыг таниулах явдал байв. Үүний хүрээнд хоол хийх сургалт, Фэйсбүүк уралдаан зохион байгуулсан. Монгол HD ТВ-н ӨНӨӨ ӨГЛӨӨ хөтөлбөрт төслийн ажилтнууд болон холбогдох зочид оролцсон. Мөн олны танил хүмүүсийг оролцуулсан хоолны нэвтрүүлэг, богино видео, инфографикуудыг тус тус хийлээ. Уг кампанит ажил нийт 1.5 сая хүнд хүрсэн.</p> <ul style="list-style-type: none"> – Монгол HD ТВ ярилцлага: төслийн 5 ажилтан Монголын шилдэг өглөөний хөтөлбөрт оролцов. Кампанит ажлын хүрээнд хүнсний ногооны чиглэлээр нийт 10 зочин уг нэвтрүүлэгт оролцсон байна. – Veggie Cook Challenge хоолны шоу олны танил жүжигчин хөтөлж, 5 дугаарт олны танил эрхмүүдийг оролцуулсан бөгөөд Фэйсбүүкт 1.2 сая хүнд хүрчээ. – Veggie Cook Challenge Фэйсбүүк уралдаан нь хүнсний ногоогоор хоол хийж, жор хуваалцах зорилготой байсан бөгөөд 27 бүтээл хүлээн авсан. Сурталчилгаа болон контент 299'583 хүнд хүрсэн байна. – Бүтээлч контентууд: хүнсний ногооны 40, хоолны жорын 17 инфографик болон 10 богино видео хийгдсэн. – Gogo.mn – д нийтлэгдсэн Монгол Улсын хүнсний ногооны зах зээлийн талаарх нийтлэл 12'500 хүнд хүрчээ. <p>Хэвлэл, мэдээлэл Хүнсний ногооны зах зээлийн форум, намрын ногоон өдрүүд үзэсгэлэн худалдааны үеэр төслийн зүгээс хэд хэдэн хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтарч ажилласан. Мөн Veggie cook show кампанит ажил нь хэрэглэгчдийн боловсролыг дээшлүүлэх медиа кампанит ажил байлаа. Дээрх ажлуудын хүрээнд нийт 18 хэвлэл мэдээллийн хэрэгсэл, үүнд 9 телевиз, 3 сонин, 1 вэбсайт, 2 ФМ радио, 2 сошиал медиа суваг ашиглав. Нийтдээ 1.5 сая хүнд хүрсэн. Төслийн зүгээс 83 дизайн, 18 видео хийсэн байна. Дэлгэрэнгүй мэдээллийг хүснэгтээс үзнэ үү.</p> <p>Хүснэгт 3: Хэвлэл мэдээлэл</p> <table border="1"> <thead> <tr> <th>N</th> <th>Арга хэмжээ</th> <th>Огноо</th> <th>Хэвлэл мэдээллийн хэрэгсэл</th> <th>Хүр-тээмж</th> <th>Тайлбар</th> </tr> </thead> <tbody> <tr> <td rowspan="6">1</td> <td rowspan="6">Хүнсний ногооны маркетингийн форум</td> <td rowspan="6">11/25</td> <td>7 хэрэгсэл</td> <td>438'313</td> <td rowspan="6">Төслийн удирдагч, ШХА-н ажилтан, ХХААХҮЯамын төлөөлөгч, болон ногоочид 4 ТВ, 1 сонинд ярилцлага өгсөн. Бүх ярилцлагуудын видеог төслийн Facebook, YouTube хуудсанд тавьсан. Ярилцлагын дүнд олон нийтийн ойлголт сайжирсан.</td> </tr> <tr> <td>TV5</td> <td>100'000</td> </tr> <tr> <td>TV8</td> <td>100'000</td> </tr> <tr> <td>NTV</td> <td>100'000</td> </tr> <tr> <td>SBN</td> <td>100'000</td> </tr> <tr> <td>ХАА-н маргааш сонин</td> <td>1'000</td> </tr> <tr> <td>Facebook</td> <td>37'313</td> </tr> <tr> <td rowspan="6">2</td> <td rowspan="6">Намрын ногоон өдрүүд үзэсгэлэн худалдаа</td> <td rowspan="6">9/14-20</td> <td>9 хэрэгсэл</td> <td>510'000</td> <td rowspan="6">Үзэсгэлэн худалдааг 2 ФМ, Өдрийн Сонин болон төслийн Facebook хуудсаар сурталчилж 200.000 хүнд хүрсэн. “Ногоон хүнс – эрүүл амьдрал” нээлттэй</td> </tr> <tr> <td>ETV</td> <td>100'000</td> </tr> <tr> <td>Za TV</td> <td>50'000</td> </tr> <tr> <td>Mass TV</td> <td>50'000</td> </tr> <tr> <td>TV 9</td> <td>100'000</td> </tr> <tr> <td>Монголын мэдээ сонин</td> <td>5'000</td> </tr> </tbody> </table>	N	Арга хэмжээ	Огноо	Хэвлэл мэдээллийн хэрэгсэл	Хүр-тээмж	Тайлбар	1	Хүнсний ногооны маркетингийн форум	11/25	7 хэрэгсэл	438'313	Төслийн удирдагч, ШХА-н ажилтан, ХХААХҮЯамын төлөөлөгч, болон ногоочид 4 ТВ, 1 сонинд ярилцлага өгсөн. Бүх ярилцлагуудын видеог төслийн Facebook, YouTube хуудсанд тавьсан. Ярилцлагын дүнд олон нийтийн ойлголт сайжирсан.	TV5	100'000	TV8	100'000	NTV	100'000	SBN	100'000	ХАА-н маргааш сонин	1'000	Facebook	37'313	2	Намрын ногоон өдрүүд үзэсгэлэн худалдаа	9/14-20	9 хэрэгсэл	510'000	Үзэсгэлэн худалдааг 2 ФМ, Өдрийн Сонин болон төслийн Facebook хуудсаар сурталчилж 200.000 хүнд хүрсэн. “Ногоон хүнс – эрүүл амьдрал” нээлттэй	ETV	100'000	Za TV	50'000	Mass TV	50'000	TV 9	100'000	Монголын мэдээ сонин	5'000
N	Арга хэмжээ	Огноо	Хэвлэл мэдээллийн хэрэгсэл	Хүр-тээмж	Тайлбар																																					
1	Хүнсний ногооны маркетингийн форум	11/25	7 хэрэгсэл	438'313	Төслийн удирдагч, ШХА-н ажилтан, ХХААХҮЯамын төлөөлөгч, болон ногоочид 4 ТВ, 1 сонинд ярилцлага өгсөн. Бүх ярилцлагуудын видеог төслийн Facebook, YouTube хуудсанд тавьсан. Ярилцлагын дүнд олон нийтийн ойлголт сайжирсан.																																					
			TV5	100'000																																						
			TV8	100'000																																						
			NTV	100'000																																						
			SBN	100'000																																						
			ХАА-н маргааш сонин	1'000																																						
Facebook	37'313																																									
2	Намрын ногоон өдрүүд үзэсгэлэн худалдаа	9/14-20	9 хэрэгсэл	510'000	Үзэсгэлэн худалдааг 2 ФМ, Өдрийн Сонин болон төслийн Facebook хуудсаар сурталчилж 200.000 хүнд хүрсэн. “Ногоон хүнс – эрүүл амьдрал” нээлттэй																																					
			ETV	100'000																																						
			Za TV	50'000																																						
			Mass TV	50'000																																						
			TV 9	100'000																																						
			Монголын мэдээ сонин	5'000																																						

			Өдрийн сонин	5'000	өдөрлөгийг 4 ТВ, 1 сонинд мэдээлсэн. Үйл ажиллагааны үр дүнд ногоочид 165 сая төгрөгийн борлуулалт хийж, олон нийтийн ойлголт дээшлэв.
			FM 96.9	50'000	
			FM 104.5	50'000	
			Facebook	100'000	
3	Veggie cook show кампанит ажил	2016/11-2017/01	4 суваг	1'519'179	Төслийн 5 ажилтан шилдэг өглөөний нэвтрүүлэгт орсон. Олны танил хүмүүс хоолны нэвтрүүлэгт оролцож, өөрсдийн хуудсанд нийтэлсэн. Кампанит ажлын дүнд хэрэглэгчийн ойлголт дээшилсэн.
			Mongol HD TV	300'000	
			gogo.mn	12'500	
			Facebook	1'205'856	
			Youtube	823	
4	Дизайны ажлууд	2016/7-11 сар	Нийт	83	Нийт 101 дизайн, видео бэлтгэгдсэн байна.
			Хоолны инфографик	17	
			Сортын танилцуулга, постер	8	
			Хатаах заавар	1	
			Ногооны инфографик	40	
			Станд	7	
			Баннер, постерууд	10	
5	Видео	2016/7-11 сар	Нийт	17	
			Хоолны видео	10	
			Facebook Live видеонууд	5	
			Хүнсний ногооны форумын видео	1	
			Төслийн танилцуулга	1	
			GARAK захын видео	1	
			НИЙТ	2'467'592	
<p>Хэвлэл мэдээлэл-ХШҮ-100% Сургалтууд Борлуулалтын хоршоо, маркетинг, хүнсний ногооны боловсруулалтын чиглэлээр 4 сарын туршид 8 сургалт хийгдсэн. 13 аймгийн 378 ногоочид (66% эмэгтэй) хамрагдсан. Дэлгэрэнгүй мэдээллийг хүснэгтээс үзнэ үү. Хүснэгт 4: Сургалтууд</p>					
N	Сургалтын нэр	Огноо байршил	Оролцогчдын тоо (% эм)	Үр дүн	
1	Хоршооны сургалт	8-р сарын 8-18, Төвийн бүсийн 8 сум	173 (65% эм)	4 борлуулалтын хоршоо албан ёсоор байгуулагдаж, бүртгэгдсэн бөгөөд бусад хоршоо байгуулагдаж байна.	

2	Хоршооны удирдлага, бизнес төлөвлөлт	11-р сарын 22, Улаанбаатар	25 (32% эм)	Борлуулалтын хоршооны удирдлагуудын ур чадвар дээшилж, бизнес төлөвлөгөө боловсруулахад суралцав.
3	Маркетинг, өртгийн сүлжээ	11-р сарын 23, Улаанбаатар	60 (66% эм)	Ногоочид маркетинг, борлуулалтын үндсэн мэдлэгтэй болж, төлөвлөлт хийж суралцав.
4	Хүнсний ногоо дахин боловсруулах	9-р сарын 15, Орхон сум, Дархан-Уул аймаг	25 (60% эм)	Сэлэнгэ, Дархан, Орхон, Баян-Өлгий амйгийн ногоочид хамрагдаж 10 төрлийн даршилсан ногоо, компот хийж сурав.
5	Нэмүү өртөг бүхий үйлдвэрлэл, хүнсний ногоо хатаах технологи	11-р сарын 22, Улаанбаатар	30 (63% эм)	13 аймгийн ногоочид ногоо дахин боловсруулах бизнес, технологийн талаар суралцав.
6	Өртгийн сүлжээ	11-р сарын 23, Улаанбаатар	53 (66% эм)	Өртгийн сүлжээний сургалтын үеэр ногоочид загварын дагуу асуудлуудаа дөвшүүлэн ярилцав. Өртгийн сүлжээний сургалтыг НҮБ-н ХХАБ-н Secim 2 төслийн хамт олон олгов.
7	Дахин боловсруулах цехийн сургалт, зөвөлгөө	11-р сарын 8, Дорнод	3 (100% эм)	Төслийн зүгээс Дорнод аймгийн Хатан Шоргоолж цехэд дэмжлэг үзүүлж, газар дээр нь сургалт зөвөлгөө олгосон.
8	Ногоочдын тойрон аялал	11-р сарын 24, Улаанбаатар	41 (39% эм)	13 аймгийн ногоочид хамрагдаж E-mart хайпермаркет, Modern Nomads ресторан, Тэнгэр, Сэлэнгэ зах, Делта Холдингийн агуулахад зочлов. Үүний дүнд ногоочид зах зээлийн үйл ажиллагаатай танилцаж, бизнесийн байгууллагуудын ашиг сонирхлыг мэдэж авлаа.
9	Хүнсний ногоогоор хийх хоолны сургалт	11-р сарын 24, Улаанбаатар	21 (100% эм)	13 аймгийн эмэгтэй ногоочид сургалтанд хамрагдаж, шим тэжээл, эрүүл хооллолтын талаар мэдээлэл авч, хүнсний ногоогоор эрүүл хоол хийж сурав.
НИЙТ		19 өдөр	431 (62% эм)	

Сургалт-ХШҮ-100%

		<p>Нийт 4 (2 эр) сургагч багш богино хугацааны гэрээтэйгээр ажиллалаа. ХШҮ- 70 %</p> <p>БҮРЭЛДЭХҮҮН ХЭСЭГ 2 -ИЙН ҮР ДҮНГ ИЛТГЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН ГҮЙЦЭТГЭЛ</p> <table border="1"> <thead> <tr> <th rowspan="2">Үр дүнгийн үзүүлэлтүүд</th> <th colspan="3">2017 оны байдлаар</th> </tr> <tr> <th>Төлөвлөсөн</th> <th>Гүйцэтгэл</th> <th>Хувь</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>Зорилтот өрх бүрийн хүнсний ногооноос олох жилийн дундаж орлого</td> <td>(Жилд 250,000 <) 500,000</td> <td>793,095</td> <td>100%</td> </tr> <tr> <td>Хоршооллоор дамжуулж зарсан хүнсний ногооны хувь</td> <td>(Жилд- 7,5% <)</td> <td>0.06</td> <td>0.2%</td> </tr> <tr> <td>Хоршоолол, хувийн хэвшлийн хувиин зурагдсан идэвхтэй гэрээний тоо</td> <td>(Жилд- 4 хүртэл гэрээ) 0</td> <td>0</td> <td>0%</td> </tr> <tr> <td>Дундаж</td> <td></td> <td></td> <td>33.4%</td> </tr> </tbody> </table>	Үр дүнгийн үзүүлэлтүүд	2017 оны байдлаар			Төлөвлөсөн	Гүйцэтгэл	Хувь	Зорилтот өрх бүрийн хүнсний ногооноос олох жилийн дундаж орлого	(Жилд 250,000 <) 500,000	793,095	100%	Хоршооллоор дамжуулж зарсан хүнсний ногооны хувь	(Жилд- 7,5% <)	0.06	0.2%	Хоршоолол, хувийн хэвшлийн хувиин зурагдсан идэвхтэй гэрээний тоо	(Жилд- 4 хүртэл гэрээ) 0	0	0%	Дундаж			33.4%
Үр дүнгийн үзүүлэлтүүд	2017 оны байдлаар																								
	Төлөвлөсөн	Гүйцэтгэл	Хувь																						
Зорилтот өрх бүрийн хүнсний ногооноос олох жилийн дундаж орлого	(Жилд 250,000 <) 500,000	793,095	100%																						
Хоршооллоор дамжуулж зарсан хүнсний ногооны хувь	(Жилд- 7,5% <)	0.06	0.2%																						
Хоршоолол, хувийн хэвшлийн хувиин зурагдсан идэвхтэй гэрээний тоо	(Жилд- 4 хүртэл гэрээ) 0	0	0%																						
Дундаж			33.4%																						
<p>БҮРЭЛДЭХҮҮН ХЭСЭГ 3: ГЭР ХОРООЛОЛЫН ХҮНСНИЙ НОГООНЫ ҮЙЛДВЭРЛЭЛ</p> <p>3-р зорилтын хүрээнд:</p>	<p>Бүтээгдэхүүн 3.1-ийн үйл ажиллагаа: Хот болон хот орчмын эмзэг, бүлгийн (ялангуяа өрх толгойлсон эмэгтэй) өрхүүдийн хүнсний ногоо тариалалт нэмэгдсэн байна</p> <p>1. “Жишиг гудамж”</p> <p>Жишиг гудамж нь хашаандаа ногоо ургуулж, хашааныхаа талбайг хэрхэн зөв зохистой ашиглаж болохыг хөршүүд болон гэр хороололд ижил нөхцөлд амьдардаг өрхүүдэд үзүүлэх загвар гудамж юм. Хашаандаа ногоо ургуулснаар тухайн өрхийн хүнсний тэжээлэг чанар нэмэгдэхийн зэрэгцээ орлого тодорхой хувиар нэмэгддэг. Төслийн дэмжлэг авсан жишиг гудамжийн өрхүүд хашаандаа ил болон хамгаалалттай талбайд ногоо тариалахыг суралцлаа. Энэхүү жишиг гудамж нь цаашид бусад гудамжны өрхүүдэд зөвлөгөө, туршлагаа хуваалцах үүрэгтэй юм.</p> <p>Гэр хороололын ядуу өрхийн хашаанд ногоо тариалахад хамгийн бэрхшээлтэй асуудал нь ногоо услах ус байсан. Энэ асуудлыг шийдэх загвар бий болгох зорилгоор 4 гүний худаг гаргаж, ногоо тариалах 61 өрхийн ус зөөх ажлыг хөнгөвчилж өгсөн нь өмнө нь хэрэгжиж байгаагүй шинэлэг ажил болсоноос гадна нэгж талбайн ургацыг нэмэгдүүлэх, гудамжаараа баг болж бизнес эрхлэх, гэр хорооллын хүнсний аюулгүй байдлыг сайжруулах зэрэгт нөлөөлөх сайн туршлага болсон. Мөн төрөл бүрийн сургалтанд хамрагдаж, дэмжлэг авснаар нийт үр шим хүртэгчид 8га талбай (үүнээс 2га хүлэмж)-гаас 6.7 сая төгрөгийн өртөг бүхий 16.3т хүнсний ногоо хураан авчээ. 84 цэгт хөрс, усны шинжилгээ хийлгэсэн ба үр дүн нь сайн гарч гэр хороололд ногоо тариалж хүнсэндээ хэрэглэж болохыг баталгаажуулсан.</p> <p>Худаг гаргах зардлын 10%-тай тэнцэх хэмжээний хөрөнгийг өрхүүд өөрсдөө гаргалаа.</p>	 <p>Зураг 11: Жишиг гудамж гүний худагтай</p>																							

	<p><u>“Жишиг өрх”</u> Жишиг өрх нь хашаандаа ногоо ургуулах мөн цаашид бусад хөрш өрхүүдтэйгээ олон мэдлэг, туршлагаа хуваалцах, сургах үүрэгтэй өрх юм. Ерөнхийдөө үүрэг зорилго нь жишиг гудамжтай ижил. Нийт 3 дүүргийн 6 өрх жишиг өрхөөр сонгогдон төслийн дэмжлэг авлаа.</p> <p><u>Амжилтын түүх:</u> Л.Тодгэрэлийн гэр бүл Налайх дүүргийн 3-р хорооны Нарангийн 31-4 тоотод амьдардаг Л.Тодгэрэлийн эхнэр Б.Дэжид: Би нөхөр 3-н хүүхдийн хамт амьдардаг, нэг хүүхэд маань хөгжлийн бэрхшиэлтэй учраас хүүхдүүдээ асарч гэртээ байж нөхөр маань тогтмол ажилгүй, тохиролцооны ажил хийж орлого олох нь гэр бүлийн амьжиргаанд хүрэлцэхгүй байсан учраас ногоо тарих санаа төрж, 2010 онд анх зөвхөн төмс тарьж эхэлж байлаа. Үүнээс хойш жил бүр манжин, лууван, байцаа, навчит ногоо гэх мэт ногооныхаа нэр төрлийг нэмэгдүүлэн тариалж ирсэн. Зөвхөн өөрийн бага талбайтай хашаандаа хүнсний ногооны тарьж, өрхийн хэрэгцээнээс илүү гарсан ногоогоо зарж жилд 200'000-300'000 төгрөг олдог байсан. 2016 онд “Монгол ногоо” төсөлд хамрагдаж 4x8 хэмжээтэй дуслын усалгааны систем бүхий хүлэмж, гүзээлзгэний 200 ширхэг үрсэлгээ авч тарьсанаар шинэ таримал тариалж сурч, гүзээлзгэний үрсэлгээ ургуулж сурчээ. Одоогийн байдлаар гүзээлзгэний 300 ширхэг суулгац бэлдээд байна. Үүнийгээ нэг ширхэгийг нь 5'000 төгрөгөөр зарахад 1'500'000 төгрөг болно. Мөн төслийн хүрээнд хүнсний ногооны хатаалтын технологийн сургалтанд сууж ногоо хатааж сурч өрхийн хэрэгцээнээс илүү гарсан ногоогоо хатааж зарах боломжтой боллоо. Ногоог хатааж савлаж зарахад үнэ нь 2-3 дахин нэмэгдэх боломжтой болдог учир энэ жилээс ногооноос нийт 2'000'000 төгрөгийн орлого олоход байна. Төсөлд хамрагдан онолын болон дадлага сургалтуудад хамрагдаж, ногоо тарьж байгаа өрх, аж ахуйн нэгжийн ногооны талбайгаар явж туршлага судлах аялалд оролцсон нь надад тарьж ургуулах хүслийг улам нэмэж, илүү их ажиллах эрч хүч, сонирхолтой болголоо. Энэ жил шинэ таримал тарьж, хүнсний ногоогоо хатаах шинэ технологийг сурсан нь манай өрхийн орлого нэмэгдэж, хүүхдүүд маань амтлаг жимс ногоо идэж, цаашид илүү боломж байгааг олж харсан.</p> <p><u>Сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдэд хүнсний ногооны ач холбогдлыг таниулах</u> Сурагчдын экологийн боловсролыг нэмэгдүүлэх, хүүхдээр дамжуулан хашаандаа ногоо тарих ажлыг өргөжүүлэх зорилгоор гэр хорооллын 3 сургуулийн хүүхдийн танин мэдэхүйн мэдлэгт туслах, цэцэрлэгийн талбайд тариалсан шим тэжээлт ногоогоор хүүхдийн хоолны орц найрлагыг сайжруулахад нөлөөлөх зорилгоор гэр хорооллын 3 цэцэрлэгийг тус тус сонгож, ногоо тариалах аргад багш, ажилчид, эцэг эхчүүд, хүүхдүүдийг суралцууллаа.</p>
--	--



Зураг 12: Жишиг өрх, Тодгэрэлийн гэр бүл

Хүснэгт 5: Зорилтот дүүргүүдийн үр шим хүртэгчдэд үзүүлсэн дэмжлэг (төгрөгөөр)

Дүүрэг	Багаж тоног төхөөрөмж	Үр, үрсэлгээ	Өрхийн оруулсан хувь	Нийт хөрөнгө оруулалт
Сонгино-Хайрхан	38,396,427	2,945,858	3,486,199	44,828,484
Хан-Уул	24,346,280	1,244,036	4,559,996	30,150,312
Налайх	40,203,330	2,635,807	8,045,000	50,884,137
	102,946,037	6,825,701	16,091,195	125,862,933

ХШҮ- 90 %

Бүтээгдэхүүн 3.2-ийн үйл ажиллагаа: Хот болон хот орчмын бүсэд хүнсний ногооны хэрэглээ нэмэгдсэн байна.

Тогтмол хэрэглэж чаддаггүй шим тэжээлт ногоо тариалж жилийн туршид хэрэглэх аргад сургах зорилгоор хэрэглээний сургалтууд зохион байгуулах ажлын хүрээнд: Шим тэжээлт ногоогоор хоол хийх сургалтыг хоол тэжээлийн мэргэжлийн сургалтын төвтэй, хүнсний ногоо дахин боловсруулах, жилийн туршид шим тэжээлт чанарыг нь алдагдуулахгүй хадгалж хэрэглэх технологийн сургалтыг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвтэй, бизнесийн мэдлэг олгох болон маркетингийн сургалтыг Гадаад орчны боловсролын институттэй тус тус хамтарч 6 удаагийн сургалт зохион байгууллаа. Сургалтанд 643 хүн хамрагдсаны 480 нь эмэгтэйчүүд байлаа. Сургалтын үр дүнд сурсан зүйл, ургуулсан ногоогоороо 2 өрх Намрын ногоон өдрүүд арга хэмжээнд оролцож, 126 шил нөөшилсөн, 423 уут хатааж савалсан ногоог борлуулж 386'000 төгрөгний орлого олох боломж бүрдсэн. Мөн 2 жишиг гудамжны 4 өрх 1.3т төмс хүнсний ногоо борлуулж, 650'000 төгрөгний борлуулалт хийжээ.



Зураг 13: Талбайн сургалт

Зорилтот сургууль цэцэрлэгүүдэд төмс хүнсний ногоо тариалах арчлах сургалтуудыг тус бүр 4 удаа зохион байгуулж, давхардсан тоогоор 472 хүн хамрагдсаны 95% эмэгтэй байна. Нийт сургалтанд

оролцогсдын 132 нь Ерөнхий боловсролын сургуулийн эко клубын сурагчид байсан.

Бүтээгдэхүүн 3.2-ийн үйл ажиллагаа: Эмзэг бүлгийн өрхүүд сургалтанд хамрагдаж мэдлэг мэдээлэлээр хангагдсан байна.

Хүснэгт 7: Сургалтууд

№	Сургалтын нэр	Огноо байршил	Оролцогчдын тоо (% эм)	Үр дүн
1	Тариалалт	21 удаа, Улаанбаатар	888 (76% эм)	Нийт 9 дүүргийн 2'458 өрх төрөл бүрийн сургалтанд хамрагдсанаар нийт 898га талбайд ногоо тариалж 10.6 мянган тонн ногоо хурааж авчээ. (Нийслэлийн хөдөө аж ахуйн газрын мэдээгээр)
2	Тариаланчдын зөвлөгөөн	2 удаа Хан-Уул, Сонгино-хайрхан	384 (60% эм)	
3	Ил болон хамгаалалттай хөрсний ургамал	9 удаа Улаанбаатар	474 (63% эм)	

		хамгаалал, арчилгаа			Зорилтот бүлгүүдийн сургалтанд хамрагдсан 68 өрх, 3 сургууль, 3 цэцэглэгнийг 8га (2га хүлэмж)-аас 13.3т буюу 6.7 сая төгрөгийн өртөг бүхий ургац хураажээ.
		4 Компост бордоо бэлтгэх	1 удаа Улаанбаатар	90 (60% эм)	
		5 Эдийн засаг, маркетинг	1 удаа Улаанбаатар	65 (18% эм)	
		6 Хүнсний ногоо боловсруулах	1 удаа Улаанбаатар	153 (99% эм)	Сургалтын үр дүнд сурсан зүйл, ургуулсан ногоогоороо 2 өрх Намрын ногоон өдрүүд арга хэмжээнд оролцож, 126 шил нөөшилсөн, 423 ууг хатааж савалсан ногоог борлуулж 386'000 төрөгний орлого олох боломж бүрдсэн. Мөн 2 жишиг гудамжны 4 өрх 1.3т төмс хүнсний ногоо борлуулж, 650'000 төгрөгний борлуулалт хийжээ.
		7 Хоол, хүнс тэжээл	3 удаа Улаанбаатар	171 (89% эм)	
		8 Дотоодын туршлага судлах аялал	1 удаа Улаанбаатар	87 (56% эм)	Ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг төрийн болон гадаад дотоодын ТББ-уудад төслийн үйл ажиллагаа, үр дүнг танилцуулах ажлыг зохион байгуулсан. Үүнд гадаад, дотоодын ТББ, ХХААХҮЯ, нийслэл хот, дүүргүүдийн удирдлага мэргэжилтэн, тариаланчдын төлөөлөл оролцсон. Тэд гэр хороололд амьдардаг орлого багатай өрхүүдийг нэгтгэж бүлэг нөхөрлөл болж ажиллахад нь туслах, гэр хорооллын төмс хүнсний ногооны үйлвэрлэлийг нэмэгдүүлэхэд бодит туслалцаа үзүүлсэн цогц арга хэмжээ болжээ гэж дүгнээд баяр хүргэсэн. ХХААХҮЯ-ны төлөөллүүд цаашид үлгэр жишээ болохуйц зөв шийдэлтэй төсөл гэж үнэлсэн.
		9 Оролцогч талуудын уулзалтууд	2 удаа Улаанбаатар	42 (67% эм)	Хамран ажиллагч төрийн байгууллагуудад үйл ажиллагаагаа цаг тухайд нь мэдээлж

				байлаа.
10	Эко сургуультай танилцах аялал	1 удаа Улаанбаатар	104 (56% эм)	ШХА-ын Тогтвортой хөгжлийн боловсрол төслийн дэмжлэг бүхий эко сургуулийн үйл ажиллагаатай танилцах аялалд үр шим хүртэгч сургууль, цэцэрлэгийн багш, ажилчид, сурагчид танилцаж, шилдэг арга барилуудтай суралцлаа.
11	Гадаадад туршлага судлах аялал	1 удаа Улан-Удэ, ОХУ	28 (90% эм)	Нэгж талбайн ашиглалт, хөрс боловсруулалт, хөрсний үржил шимийг тогтвортой нэмэгдүүлэх арга, сургууль цэцэрлэгийн орчны ногоон байгууламжийг арчлах, эко орчны тохижилтыг сайжруулах арга ажиллагаатай танилцсан.
	НИЙТ	46 өдөр	2'458 (70% эм)	

Нийт 4 эмэгтэй сургагч багш богино хугацааны гэрээтэйгээр ажилласан. Мөн өрхийн тариаланчдад зориулсан технологийн гарын авлага 3'000 ширхэг, жижиг тариаланчдын ургамал хамгааллын гарын авлага 1'000 ширхэг, эдийн засгийн гарын авлага 1'000 ширхэг тус тус хэвлүүлж, сургалтанд ашиглаж байна.

ХШҮ- 90 %

БҮРЭЛДЭХҮҮН ХЭСЭГ 3 -ИЙН ҮР ДҮНГ ИЛТГЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН ГҮЙЦЭТГЭЛ

Үр дүнгийн үзүүлэлтүүд	2017 оны байдлаар		
	Төлөвлөсөн	Гүйцэтгэл	Хувь
Хүнсний ногоо тариалж буй өрхийн тоо	20% 2.185	30,1% 2.847	100%
Хүнсний ногоо тариалж, борлуулж, хэрэглэхэд үүсэх үнэ цэнэ, төгрөгөөр	33,5 сая	33,5 сая	100%
Дундаж			100%

БҮРЭЛДЭХҮҮН ХЭСЭГ 4: Хүнсний ногооны салбарын хууль эрхзүйн орчин

4-р зорилтын хүрээнд:

Хүнсний ногооны сорт, үр, ургамал хамгааллын тухай холбогдох хуулийн заалтууд шинэчлэгдээгүй эсвэл хуулинд тодорхой тусгагдаагүй байдаг тул үүнийг олон улсын стандартад нийцүүлэхэд дэмжлэг үзүүлэх ажлын хүрээнд: Таримал ургамлын үр, сортын тухай хуулийн хэрэгжилтийн байдалд үнэлгээ өгөх ажлын тайлан анхны байдлаар бэлэн болов. Үүнтэй холбогдуулан эрдэмтэн-судлаачид, төрийн захиргааны албан тушаалтан, үйлдвэрлэгчид, ногоочдын төлөөлөлтэй уулзаж хүнсний ногооны шинэ сорт бүтээх, сорих, үр үйлдвэрлэл, нийлүүлэлт, хангамж, хүрэлцээ, үрийн чанарт тавих хяналт болон энэ салбарын хөгжил, олон улсын чиг хандлага, энэ салбарт улсын төсвөөс хуваарилж байгаа

		<p>хөрөнгө, санхүүгийн өнөөгийн байдал, тус салбарт хэрэгжиж байгаа хууль, эрх зүйн орчин, учирч байгаа хүндрэл бэрхшээл, гарах арга зам, эрхзүйн орчноор зохицуулах шаардлагатай харилцаа зэргийн талаарх тэдний санаа, оноог сонссон. Түүнчлэн холбогдох хууль тогтоомж, бусад эрх зүйн баримт бичгүүд болон Таримал ургамлын үр, сортын тухай, Зохиогчийн эрх, түүнтэй холбогдох бусад эрхийн тухай болон Патентийн тухай хуулиудын батлагдаж байх үеийн үзэл баримтлал болон холбогдох бусад материалуудыг цуглуулж судлав.</p> <p>Ургамлын шинэ сортын хамгаалах тухай олон улсын конвенцийг монгол хэл дээр хөрвүүлж, Бангкок дахь НҮБ-ын ХХААБ-ын холбогдох мэргэжилтнээр хянуулахаар хүргүүлсэн. ХШҮ-30 %</p>
7	Дүгнэлт (ололт, дутагдал, анхаарах асуудлууд)	<p>Монгол ногоо төсөл хэрэгжсэнээр дараах бодит үр дүнгүүд гарч эхлээд байна.</p> <p>2016 онд нийт 8,342 га талбайд хүнсний ногоо тариалсан нь 2015 (6'803га) оны тариалалтаас 18 %-иар өссөн үзүүлэлттэй байсан бол ургацын дундаж 10.7 тн-оос (2015 он) 11.2 тн (2016 он) болж нэмэгджээ. Хүнсний ногооны үйлдвэрлэлийн хэмжээ 72,741т-оос (2015 он) 93,529т (2016 он) болж өссөнөөр дотоодын нийт үйлдвэрлэлийн хэмжээ 52% (жишсэн хүн амын тоог 2,418.5 саяар тооцлоо) болж өссөн байна. (2015 онд 35%). Засгийн газрын 185-р тогтоолоор, дотоодын хүнсний ногооны үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор импортын хүнсний ногооны гаалийн татварыг 5-10%-иар буюу хүнсний ногооны төрөл зүйлээс хамаарч 20% хүртэл хувиар нэмэгдүүлсэн.</p> <p>2016 оны эхний хагас жилд газар тариалангийн төвийн бүсийн цаг уурын байдал тааламжтай байсан боловч 6, 7-р саруудад ган, хураалтын үед буюу 8, 9-р сард үргэлжилж орсон бороо зарим төвийн бүсүүдэд ургац алдахад хүргэсэн. Мөн Увс аймгийн Улаангомд 7-р сарын сүүлчээр хүчтэй мөндөр бууж, хүнсний ногооны үүнд шар манжингийн үрийн талбайн ургац 30%-иар буурсан.</p> <p>Хүнсний ногооны маркетингийн судалгаагаар, импортын хүнсний ногооны 56 гаруй хувийг байцаа, сонгино, лууван гэсэн таримлууд эзэлж байна. Мөн импортын төмс, хүнсний ногооны 85 гаруй хувийг БНХАУ-аас хангаж байна гэсэн тоо баримт байна. (Хүнсний ногооны маркетингийн судалгаа, 2016)</p> <p>Төслөөс хийсэн ядуурлын судалгааны дүнгээр, төслийн зорилтот дүүргийн нийт 14,198 өрхийн 3% нь хашаандаа төмс, хүнсний ногоо тариалдаг. Өрхийн дундаж орлого 750,000 төгрөг байна. (Ядуурлын судалгаа, 2016)</p> <p>Монгол ногоо төсөл 2016 оны 4-р сард үйл ажиллагаагаа эхлүүлсэн. Төсөл хэрэгжих хугацаа 4 жил, нийт төсөв 5 сая швейцарь франк. Төсөл хэрэгжүүлэх нэгж (ТХН) 8 хүний бүрэлдэхүүнтэйгээр ажиллаж байна. 2016 оны нийт төсөв 2.4 тэрбум төгрөг.</p> <p>2016 онд Улсын Их Хурлын сонгууль болж өнгөрсөн. Сонгуулийн дараа яам, хэрэгжүүлэгч агентлагуудын удирдлага, мэргэжилтэнүүд солигдсон, төсөл тариалалтын хугацаатай зэрэг буюу 4-р сард эхэлсэн зэрэг нь төслийн зарим үйл ажиллагаа хойшлогдоход нөлөөлсөн, мөн төслийн удирдах зөвлөл 2016 онд хуралдах тов тодорхойгүй хугацаагаар хойшилсон хэдий ч аливаа хүндрэл бэрхшээл тулгараагүй төсөл хэвийн үргэлжилсэн.</p> <p>Цаашид Монгол ногоо төслийн хүрээнд дараах ажлуудын</p>

		<p>гүйцэтгэлүүдийг сайжруулах тал дээр анхаарч ажиллах шаардлагатай байна. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Ногоочдын мэдлэг мэдээллийг нэмэгдүүлэх чиглэлээр хийхээр төлөвлөсөн ажлын хүрээнд хэд хэдэн ажлууд хангалтгүй гүйцэтгэлтэй байна. (5 га газар эрчим хүчний хэмнэлттэй хүлэмжийн үзүүлэн барих, Хүнсний ногооны үйлдвэрлэлийн мэдээллийн бааз санг үүсгэн баяжуулах гэх мэт) 2. Хүнсний ногооны маркетингийн сувгуудыг боловсронгуй болгох, борлуулалтын хоршоо байгуулах, хоршооллоор дамжуулсан хүнсний ногооны борлуулалтыг нэмэгдүүлэхэд анхаарах. 3. Монгол ногоо төслийн www.mfard.mn сайт дээрх <u>хүнсний ногооны зах зээл, үнэ ханшийн талаарх мэдээллийг бодит мэдээлэлд тулгуурлан тогтмол шинэчлэх, сайжруулах тал дээр анхаарч ажиллах.</u> 4. <u>Хүнсний ногоо боловсруулах төрөл бүрийн санаачлагыг дэмжих, нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх арга ажиллагааг төсөл хэрэгжиж буй аймаг сумдад зохион байгуулах ажлын үр дүнг сайжруулах.</u> 5. Бүрэлдэхүүн хэсэг-4 болох Хүнсний ногооны салбарын бодлого хууль, эрх зүйн орчинг тогтвортой болгох зорилтыг эрчимжүүлэх, тухайн чиглэлээр ХХААХҮЯ-ны холбогдох газар хэлтсүүдтэй хамтын ажиллагаа, уялдааг сайжруулан ажиллахыг анхаарах. 					
8	Төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд өгөх хөндлөнгийн үнэлгээ	<p>Европын холбооны санхүүжилттэй, НҮБ-ын ХХААБ-ын хэрэгжүүлж буй “Ажлын байрыг нэмэгдүүлэх төсөл”-тэй үйл ажиллагаагаа уялдуулан ажиллаж эхэллээ. Мөн ШХА-ын “Тогтвортой хөгжлийн боловсрол” (ТХБ) төсөлтэй хамтран эко сургуулиудын үйл ажиллагааг дэмжин ажилласан. Нийслэлийн засаг даргын даргын тамгын газрын холбогдох хэлтсүүдтэй хамтран Улаанбаатар хотын гэр хорооллын газар тариалангийн үйлдвэрлэл, хүнсний ногооны хэрэглээг нэмэгдүүлэх чиглэлээр ажиллаж байна. Хүнсний ногооны чиглэлээр гэр хороололд үйл ажиллагаа явуулдаг бусад гадаад, дотоодын төрийн ба төрийн бус тухайлбал, Дэлхийн зөн, АДРА, КАРИТАС, Глобал коммонитис зэрэг байгууллагуудтай үйл ажиллагаагаа уялдуулан ажиллаласан.</p> <p>Төслийг хэрэгжүүлэгч талууд бололцоо, нөөцөө дайчлан хамтын ажиллагааг зохих түвшинд хэрэгжүүлж ажилласан.</p>					
9	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт	Биелэлт дундаж	Зорилтын тоо	Зорилт 1	Зорилт 2	Зорилт 3	Зорилт 4
	Тухайн жилийн гүйцэтгэлийн үнэлгээ	66 %	4	84 %	60 %	90 %	30 %
10	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн нэгдсэн үнэлгээ (ЗГХЭГ-ын үнэлгээ)	Нэгдсэн үнэлгээ					